



ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2022 ОНЫ 03 ДУГААР САРД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2022.03.25


Дархан-Уул аймаг

1. ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Газар зохион байгуулалтын төлөвлөлт, өмчлөлийн чиглэлээр:

Газар зохион байгуулалт төлөвлөлт:

- ✚ 2022 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан Дархан сумын 12, 13 дугаар багийн нутаг дэвсгэрт нийт 5 байршилд газар эзэмшүүлэх дуудлага худалдааг зохион байгуулахаар аймгийн Засаг даргын 2022 оны 01-А/49 дугаар захирамжаар 2022-04-08 -ны өдөр зохион байгуулан ажиллахаар төлөвлөн ажиллаж байна.



ЭГЛЭЛЦҮҮД НИЙЭЛЭГДЭХ ЭНУ АЖИРАА ХЭРЭГЭЭТ	НИЙЭЛЭГ НИЙЭЛЭГ ХЭРЭГЭЭТ ДУУ БИ	БННЭЛЭГ НИЙЭЛЭГ ХЭРЭГЭЭТ НИЙЭЛЭГ	НИЙЭЛЭГ НИЙЭЛЭГ ХЭРЭГЭЭТ НИЙЭЛЭГ	НИЙЭЛЭГ НИЙЭЛЭГ ХЭРЭГЭЭТ НИЙЭЛЭГ	НИЙЭЛЭГ НИЙЭЛЭГ ХЭРЭГЭЭТ НИЙЭЛЭГ	НИЙЭЛЭГ НИЙЭЛЭГ ХЭРЭГЭЭТ НИЙЭЛЭГ	НИЙЭЛЭГ НИЙЭЛЭГ ХЭРЭГЭЭТ НИЙЭЛЭГ	НИЙЭЛЭГ НИЙЭЛЭГ ХЭРЭГЭЭТ НИЙЭЛЭГ
000.000.00	?	ДЭЛЭГ НИЙЭЛЭГ НИЙЭЛЭГ	0000	0-8 БННЭЛЭГ НИЙЭЛЭГ	0000	НИЙЭЛЭГ НИЙЭЛЭГ ХЭРЭГЭЭТ НИЙЭЛЭГ	0000	00000000
000.010.00	?	ДЭЛЭГ НИЙЭЛЭГ НИЙЭЛЭГ	1000	0-8 БННЭЛЭГ НИЙЭЛЭГ	0000	НИЙЭЛЭГ НИЙЭЛЭГ ХЭРЭГЭЭТ НИЙЭЛЭГ	0000	00000000
000.000.00	?	ДЭЛЭГ НИЙЭЛЭГ НИЙЭЛЭГ	0000	0-8 БННЭЛЭГ НИЙЭЛЭГ	0000	НИЙЭЛЭГ НИЙЭЛЭГ ХЭРЭГЭЭТ НИЙЭЛЭГ	0000	00000000
000.111.00	?	ДЭЛЭГ НИЙЭЛЭГ НИЙЭЛЭГ	0000	0-8 БННЭЛЭГ НИЙЭЛЭГ	0000	НИЙЭЛЭГ НИЙЭЛЭГ ХЭРЭГЭЭТ НИЙЭЛЭГ	0000	00000000
000.000.01	?	НИЙЭЛЭГ НИЙЭЛЭГ ХЭРЭГЭЭТ НИЙЭЛЭГ	1100	0-8 БННЭЛЭГ НИЙЭЛЭГ	0000	НИЙЭЛЭГ НИЙЭЛЭГ ХЭРЭГЭЭТ НИЙЭЛЭГ	0000	00000000

Өмчлөл:

- ✚ Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд өөрчлөлт орсноос хойш аймгийн хэмжээнд газар өмчлөх эрхээ бусад аймаг, орон нутагт хэрэгжүүлэхээр хүсэлт гаргасан 58 иргэнд лавлагаагаар үйлчилсэн байна.
- ✚ Дархан-Уул аймгийн хэмжээнд Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль хэрэгжиж эхэлсэнээс хойших хугацаанд өмчлүүлсэн газрын судалгааг гаргаж ажилласан.
- ✚ Аймгийн хэмжээнд 2022 онд 445 иргэнд 33,94 га буюу хуучин эзэмшиж байгаа газрыг газрыг өмчлүүлэхээр төлөвлөсөн.
- ✚ Дархан сумд 1, 2, 3, 5, 6, 7, 8, 15, Малчин багийн нутаг дэвсгэрт 195 иргэнд 13,87 га газрыг 2022 онд өмчлүүлэхээр батлагдсан.
- ✚ Дээрх судалгааны ажлын боловсруулалтыг 4 дүгээр сард хийж гүйцэтгэн ажиллана.

Газар зохион байгуулалтын төлөвлөгөө сурталчлах талаар:

- ✚ Дархан-Уул аймгийн 2022 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг сурталчлах ажлыг байгууллагын www.darkhan.gazar.gov.mn цахим хуудас болон фэйс бүүк, www.Egazar.gov.mn цахим хуудсаар иргэн аж ахуйн нэгж байгууллагад ил тод нээлттэй сурталчлах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.
- ✚ Тухайн сард www.egazar.gov.mn цахим хуудаснаас 2022 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан байршлыг харах



зааварыг орон нутгийн телевиз болох TV -12, RJB телевиз, DBS телевизээр иргэн, хуулийн этгээд, олон нийтэд мэдээллийг өгч ажилласан.



- ✚ “Дархан сумын нутаг дэвсгэрт мал болон тулах аж ахуй эрхлэхийг хориглох бүс тогтоох шийдвэрийн хэлэлцүүлэг” хурал 2022 оны 03 дугаар сарын 23 - ны өдөр сумын Засаг даргын тамгын газрын хурлын зааланд болсон.



Газрын хянан баталгаа, мониторингийн чиглэлээр:

- ✚ Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны 19 тайланг баталгаажуулсан, 6 тайланг хянаж буцаасан, захиалгат хянан баталгааны 16 мэдэгдэх хуудас үүсгэсэн.

Газрын кадастр, бүртгэл чиглэлээр:

- ✚ Газар эзэмших эрхийн гэрээ гэрчилгээ шинэчлэх хүсэлтэй 14 иргэний газарт дундын мэдээллийн сангаар дамжуулан Э дугаар авч газар эзэмших эрхийн цахим гэрээ гэрчилгээг үүсгэсэн.
- ✚ 2022 оны 03 сарын 07 өдрийн 01-A/50, 01-A/51 тоот захирамжинд орсон нэр шилжих 39 , хугацаа сунгах 1 иргэний гэрээ гэрчилгээг үүсгэн архивт хүлээлгэн өгсөн.

Газрын эрх зүйн харилцааг хянан шийдвэрлэх хурлаар:

- ✚ Талбайн хэмжээ өөрчлөх-5, Газар эзэмших эрх шилжих-20 иргэний хурлын материал бэлдсэн.

Геоземи, зураг зүйн, кадастрын чиглэлээр:

- ✚ Хаягийн зургийн дагуу 6 иргэн, 2 аж ахуйн нэгжийн эзэмшлийн газар, үл хөдлөх эд хөрөнгөд хаяг дугаар олгосон.
- ✚ Шинээр үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ авахаар /хувийн сууц , гараж, барилга байгууламж/ хэмжилт хийлгэсэн 6 иргэн, 0 аж ахуйн нэгжийн материалыг хүлээн авч мэдээлийн санд оруулж кадастрын зураг гаргасан.
- ✚ Өмчлөх эрхээ бусдад шилжүүлэх хүсэлтээ цахимаар ирүүлсэн 10 иргэний материалыг хянаж өмчлөх эрхийг шилжүүлсэн.



- ✚ Геодези, зураг зүй, кадастрын зураглалын ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй “Гео од”, “Ёлт сүрвэй” ХХК-ний хийж гүйцэтгэсэн
- ✓ Үйлчилгээтэй 63-н айлын орон сууцны барилга
- ✓ “Баян бридж” ХХК-ны нийтийн орон сууц
- ✓ Гахайн аж ахуйн гадна 6кв, 0.4 кв цахилгааны шугамын гүйцэтгэлийн ажлыг шалгаж хүлээн авсан.
- ✚ Цагдаагийн газрын мөрдөн байцаах тасагт шалгагдаж байгаа гэмт хэргийн бүртгэлийн 221800056, 221800057, 221800058, 221800082, 221800095, 221800113 дугаартай гомдол мэдээлэлд өгөгдсөн цэгийн байршлыг харуулсан зургийг хүргүүлсэн.
- ✚ Багуудын оноосон нэрийг аймгийн болон сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралд танилцуулж тогтоол гаргуулах ажлын хүрээнд багуудын нэрийг сумын Засаг даргын зөвлөл болон сумын Газар зүйн нэрийн салбар зөвлөлийн хурлаар хэлэлцэж санал дүгнэлтээ ирүүлэхийг хүссэн албан бичгийг хүргүүлсэн.

Газрын төлбөрийн талаар:

✚ Дархан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 28 дугаар тогтоолын дагуу Дархан сумын 5-н байршилд Газрын дуудлага худалдааг 2022 оны 04-р сарын 08-ны өдөр зохион байгуулахаар аймгийн Засаг даргын 2022.03.04-ны өдрийн 01-А/49 дүгээр захирамж гаргуулж, газрын биржийн цахим систем /www.mle.mn/-д байршуулсан.

✚ Газрын төлбөрийн тухай хуулийн 6.3-д 2021.07.07-ны өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт орж "сум, дүүргийн" гэснийг "аймаг, нийслэлийн" гэж өөрчлөлт оруулсан бөгөөд 2022.01.01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаатай холбогдуулан Дархан-Уул аймгийн хэмжээнд “Газрын төлбөрийн итгэлцүүрийг хэрэглэх газрын зааг, хязгаар, итгэлцүүрийн тоон утга”-ыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн ээлжит 9 дүгээр хуралдаанаар 2022.03.21-ний өдөр хэлэлцэн батлууллаа.

✚ 2022 оны 03-р сарын 25-ний өдрийн байдлаар аймгийн хэмжээнд 1.5 тэрбум төгрөгийн газрын төлбөрийн нэхэмжлэл үүсгэж Татварын удирдлагын нэгдсэн системд илгээсэн байна.

№	Сумын нэр	Нэхэмжлэл үүссэн дүн	Нэхэмжлэлийн тоо
1	Дархан	1,113,113,404.00	5229
2	Орхон	28,877,323.00	665
3	Хонгор	295,034,212.00	2830
4	Шарын гол	94,704,969.00	273
	НИЙТ	1,531,729,908.00	8997

Шарын гол сум

- ✚ Сумын засаг даргын захирамжаар 1 иргэний өмчилсөн газрын талбайн хэмжээ өөрчилж, 2 иргэний хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэсэн.



Газар эзэмших эрхийн гэрээ гэрчилгээ шинэчлэх хүсэлтэй 2 иргэний дундын мэдээллийн сангаар дамжуулан Э дугаар авч газар эзэмших эрхийн гэрчилгээг бичиж гэрээ байгуулсан. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчилж авсан иргэний мэдээллийг нөхөн бүртгэж мэдээллийн санд оруулсан.

Үүрэг даалгавар:

- ✚ Суманд идэвхгүй 112 нэгж талбар байна. Үүнд: 2 давхарын нийтийн орон сууц-31, Төрийн захиргааны байгууллага-4, Худалдаа үйлчилгээний газар-1, Автомашины гараж-6, Гэр, орон сууцны хашааны газар-38, Биеийн тамир газар-1, Эзэмшил ашиглалтад олгоогүй газар-1, Хүүхдийн зуслан-4, Ашиглалт, олборлолт явуулж буй талбай-26, Засаг даргын захирамжаар эзэмшүүлж, өмчлүүлсэн буюу нөхөн бүрдүүлэх 47 нэгж талбар байна. Мэдээллийн санд огт бүртгэлгүй 20 автомашины гараж, 2 гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчилсөн газар байна.
- ✚ Улсын тэргүүний суманд явуулах шалгуур үзүүлэлтийн дагуу 2019-2021 оны газар ашиглалтын чиглэлээр танилцуулга бэлтгэн сумын ЗДТГ-т хүргүүлсэн.

Орхон сум

- ✚ Сумын засаг даргын захирамжаар нийт 44 иргэний хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн. Үүнээс газар эзэмшүүлэх 17, хугацаа сунгах 1, өмчилсөн газрын талбайн хэмжээ өөрчлөх 9, эзэмшил газрын талбайн хэмжээ өөрчлөх 6, газар эзэмших эрхийг бусдад шилжүүлэх 11 хүсэлт хүлээн авч шийдвэрлэсэн байна. Газар зохион байгуулалтын цахим системд бүртгэлгүй Орхон сумын 1, 2-р багийн нийт 46 иргэнтэй холбогдож нөхөн бүрдүүлэлтийн ажилтай холбоотой мэдээллийг хүргэсэн үүнээс 21 иргэн ирж нөхөн бүрдүүлэлтэнд хамрагдсан байна.

Газрын кадастр, бүртгэл чиглэлээр

- ✚ Газар эзэмших эрхийн гэрээ гэрчилгээ шинэчлэх хүсэлтэй 27 иргэний газарт дундын мэдээллийн сангаар дамжуулан Э дугаар авч газар эзэмших эрхийн гэрчилгээг бичиж гэрээ байгуулсан. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчилж авсан иргэний худалдах худалдан авах гэрээ 28, кадастрын зургаар 41 иргэнд үйлчилсэн. 2022 онд зохион байгуулах газрын дуудлага худалдааны байршлын схем зургийг хийж хянуулсан.
- ✚ Газрын кадастрын мэдээллийн санд нөхөн бүрдүүлэлтийн ажлаар цахим системд 21 иргэний мэдээллийг оруулсан байна.

Газрын төлбөр болон газар эзэмших дуудлага худалдааны чиглэлээр:

- ✚ 2022 онд ногдуулалт хийгдээгүй 25 иргэний газрын төлбөрийг шинээр нэхэмжлэл үүсгэсэн байна. Тайлант хугацаанд нийт 9 иргэнтэй газрын төлбөрийн тооцоо нийлсэн.

Хонгор сум

2. БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН



Барилгын хяналтын чиглэл:

Барилга байгууламжийн ашиглалтад оруулах комиссыг зохион байгуулсан талаар:

✚ Засгийн газрын 2011 оны 212-р тогтоолоор батлагдсан Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм, Дархан-Уул аймгийн засаг даргын 2021 оны 01-А/313 тоот томилогдсон захирамжийн дагуу барилгын техникийн бичиг баримтыг хянаж үзэн 7 барилгад ашиглалтад оруулах үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан. Үүнд:

- “Дархан өргөө” политехникийн коллежийн 2 давхар, 24*18 хэмжээтэй өргөтгөлийн барилга
- “Сая сая болор” ХХК-ний 6кВ-ын гадна цахилгааны агаарын шугам 100кВА чадалтай АТП дэд станцын цахилгаан хангамжийн угсралтын ажил



- Дархан-Уул аймаг Хонгор сум Зулзагын голын амралтын бүсэд иргэн Б.Банзрагчийн 6/04кВ дэд станц 63кВА чадалтай
- “Бурхант эко асфальт” ХХК 6кВ цахилгааны агаарын шугам, 630кВА цахилгааны дэд станцын угсралтын ажил
- Эрүүл мэндийг дэмжих төвд шаардлагатай эмнэлэгийн тоног төхөөрөмж, их засварын ажил





- “Газар буудай” ХХК-ний оффис, үйлчилгээний барилга



- Улсын хөрөнгө оруулалтаар хийгдсэн 2200 хүний суудалтай спорт цогцолборын гадна цахилгааны шугамын ажил



Барилга байгууламжийг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон талаар:

- ✚ Засгийн газрын 2021 оны 213 дүгээр тогтоолын дагуу барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг 7 барилга байгууламжид олгосон. Үүнд:
 - Дархан сум, 15-р баг 960 хүүхдийн сургуулийн барилга
 - Дархан-Уул аймаг, Хонгор сум, 1-р баг, Их оч ХХК-ны агуулахын барилгын 6кВ ЦДАШ, 6/0.4кВ-ын 25кВА дэд станц цахилгаан хангамж
 - Дархан сум, 3, Өргөө, 7, 12, 16-р багуудад Хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах төсөл
 - “Баян бридж” ХХК-ний 108 айлын 2-р ээлжийн нийтийн орон сууцны барилга
 - “Батур хайрхан” ХХК-ний үйлдвэрийн барилга
 - Иргэн Ц.Ганбаярын 18*34 хэмжээтэй 1 давхар зорьтой, 10 давхар нийтийн орон сууцны барилга
 - Иргэн Д.Зоригтбаатарын 108-н айлын нийтийн орон сууцны барилга

Ирүүлсэн албан бичигт хариу өгсөн талаар:


- Барилгын хөгжлийн төвд Дархан-Уул аймгийн хэмжээнд 2022 оны I улирлын байдлаар барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон, ашиглалтад оруулсан мэдээллийг Барилга, хот байгуулалтын сайдын 55 дугаар тушаалын 2, 3 дугаар хавсралтын дагуу хүргүүлсэн.




- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар газарт “Барилга байгууламжийн норм, нормативын сан”-ийн үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөөнд тусгуулсан “Барилга байгууламжийн эзлэхүүн, барилга байгууламж барих эдэлбэр газрын харьцааг тодорхойлох аргачлал”-ын дүрмийн техникийн даалгавар төсөлд санал өгсөн.
- Дархан-Уул аймаг, Дархан сум, 9-р багт байрлалтай Иргэн Г.Галавсэнгэ автомашины гаражийн зориулалттай газарт барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл хүсэлтийн дагуу барилгын техникийн бичиг баримттай танилцсан. Тухайн газрын зориулалт баригдах барилгын зориулалттай таараагүй тул боломжгүй тухай албан бичгийг хүргүүлсэн.
- Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газарт Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 дэхь заалт “Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй” гэж заасан нь тухайн газар эзэмшигчийн эрхийг хүчингүй болгох үндэслэл болдог. Иймд газар эзэмших эрхийн гэрчилгээн дээрх Засаг даргын захирамжийн он, сар, өдөр бичигдсэн өдрөөс хойш 2 жил дараалан ашиглаагүй газрын барилгын эх загвар зураг /эскиз зураг/ болон байршилтын зурагнуудыг гарын үсэг зурж баталгаажуулахгүй байхыг тухай албан бичгийг хүргүүлсэн.

Инженер, дэд бүтцийн хүрээнд:

- ✚ Дархан-Уул аймгийн Засаг даргын 2022.02.28 өдрийн 01-А/45 захирамжаар Шар усны үерээс урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах тухай захирамжийн дагуу МХГ, Онцгой байдлын газар, Захирагчийн ажлын алба, Дархан сум, Шарын гол сум, Хонгор сум, Орхон сум холбогдох мэргэжилтэн албан хаагчтай хамтран үерийн усны далан, боомт, суваг үзлэг хийж сумдуудад үүрэг чиглэл өгч зурагжуулах ажлыг хийж гүйцэтгэж байна.




- ✚ “Ногоон Дархан 2032” хөтөлбөрийн мод тарих, үржүүлэх газрын байршлын зургийн гүйцэтгэж Байгаль орчны газарт хүргүүлсэн.



- ✚ Засгийн газрын 2021 оны 212-р тогтоолоор батлагдсан Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм, Дархан-Уул аймгийн засаг даргын 2021 оны 01-А/313 тоот томилогдсон захирамжийн дагуу Дархан сумын 10-р баг 5-р хороолол Газар буудай ХХК оффис үйчилгээний барилгын ашиглалтад оруулах комиссын гишүүнээр оролцсон.

Хот байгуулалтын кадастр, зураг төслийн хүрээнд:

- ✚ Нөхөн бүрдүүлэлтийн 52 иргэний өргөдлийг ажлын талбартай нь холбосон.



- ✚ Архитектур төлөвлөлтийн даалгаврын 9 хүсэлт цахимаар ирснээс 2 батлагдсан. Үүнээс ажил эхлүүлэх зөвшөөрөл цахимаар авах хүсэлтийн загвар зураг, улаан шугамыг цахимд оруулж баталгаажуулсан. Эх загвар зураг батлуулах 3 хүсэлт ирснээс 2 загвар зураг баталгаажуулсан байна.
- ✚ Мал бүхий иргэдийг хонгор суманд, гахайн аж ахуй эрхлэдэг иргэдийг орхон суманд нэгдсэн газар олгох ажлын байршлын зураг хийж гүйцэтгэсэн.



- ✚ Шинэчилсэн бүртгэлд хамрагдахаар өдөрт ирж байгаа иргэдийн мэдээллийг шалгаж 28 иргэний материалыг хүлээн авч тулалт хийсэн.

3. ЗАХИРГАА, ДОТООД АЖИЛ:

Шүүхийн мэдээлэл:

- ✚ О.Соёлмаа нарын нэхэмжлэлтэй, гуравдагч этгээдийн сөрөг нэхэмжлэлтэй хариуцагчаар ГХБХБГ-оролцсон 2022/01/13 дугаар 62 Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн Магадлалаар 2021/11/01-ний өдрийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Дугаар 16 шийдвэрийг хэвээр үлдээж, давж заалдах гомдлыг хангаагүй болно. Энэхүү давж заалдах шатны шүүхийн шийдвэрт нэхэмжлэгч талаас гомдол ирүүлсний дагуу хяналтын шатны шүүх рүү шилжсэн.
- ✚ Дархан Ти Ви ХХК-ний нэхэмжлэлтэй хариуцагчаар Аймгийн ЗД-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Золбаясах оролцсон 2022/02/10-ны өдрийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 114/ ШШ2022/0002 шийдвэрийг эс зөвшөөрч, Нэхэмжлэгч талаас Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасны шүүх хуралдааны тов зарлагдаагүй болно.
- ✚ Улаанбаатар менежмент ХХК-ний нэхэмжлэлтэй аймгийн Засаг даргад холбогдох Захиргааны хэрэгт холбогдуулж газар эзэмших эрхийг шилжүүлэхгүй байгаа нь хууль бус гэсэн нэхэмжлэлийн шаардлагад ГХБХБГ-ы ЗХАХМэргэжилтэн Б.Золбаясах хариу тайлбарыг боловсруулж Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд тайлбарыг хүргүүлсэн.

Хүний нөөц:

- ✚ 3 дугаар сард нийт 4 албан хаагч Улаанбаатар хотод Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар болон Барилга хөгжлийн төвүүдэд өөр өөрсдийн чиглэлээр 1-4 өдрийн чадавхижуулах сургалтад /томилолт авч/ хамруулсан.
- ✚ “Эрсдэлгүй хот” аяны хүрээнд 2022 оны 03 дугаар сарын 05-ны Бямба гарагийн өдрийг Дархан даяар цас мөсний цэвэрлэгээг зохион байгуулхаар төлөвлөсний дагуу тус байгууллагаас 15 албан хаагч нар оролцож



Байгууллагын гадна талын хог цэвэрлэгээ, газрын цас цэвэрлэгээний ажлыг хийсэн.

Сургалт, зөвлөгөөн:

- ✚ Барилгын хөгжлийн төвөөс аймгуудын Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга нартай зөвлөлдөх уулзалтад оролцож



- ✚ Барилгын материал үйлдвэрлэл, лабораторийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Мөнгөтөгос нь 2022.02.25-нд Жайка /Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага/-аас зохион байгуулсан Барилгын салбар дах Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны мөчлөг ба өндөр ажиллах үеийн аюулгүй ажиллагаа сэдэвтэй 8 цагийн сургалтанд хамрагдсан. 2022.03.11 нд Салбарын бүтэц тогтолцоог оновчтой тогтоох, хууль эрхзүйн орчин, норм нормативын баримт бичгийг боловсронгуй болгох цахим сургалтанд оролцов. 2022.03.18-нд Барилгын хөгжлийн төвөөс зохион байгуулсан Барилгын материал үйлдвэрлэлийн чиглэлээр цахим сургалтанд оролцов.

ОРОН НУТГИЙН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮНИЙГ "ТОХИРЛИЙН БАТАЛГААНД" ХАМРУУЛАХ ТАЛААР ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ, ЦАХИМ ЭВН ХЭРГЭЖЛЭХ АРГА ХӨМӨӨ СУРГАЛТ, ХЭЛДЦҮҮЛЭГ


Хаяв: 2022оны 03арын 18-ны өдөр 14:00 цагт цахимаар
Zoom ID: 933 444 8090
Zoom code: 123456
Хянах: Барилгын хөгжлийн төвийн курсын зааланд


ХӨТӨНӨР

№	Халдацх асуудал	Хугацаа	Илтгэгч/чиглүүлэгч
	Нээх үг хэлэх	5 мин	БХТ-ийн БМҮХ-ийн хэлтсийн дарга Д.Балдас
1	Барилгын материалын үйлдвэрлэл, чанар хяналт	20 мин	БХТ-ийн БМҮХ-ийн Өүтгэгдэхүүний баталгаажуулалт тооцрын үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Түвшин БХТ-ийн БМҮХ-ийн технологийн заавар хариуцсан мэргэжилтэн М.Доржпэл
	Асуулт, хариулт		
2	Барилгын хөдөлмөрийн аюулгүйн системийн танилцуулга	20 мин	БХТ-ийн БМҮХ-ийн Барилгын салбарын технологийн мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн Н.Энхжаргал
	Асуулт, хариулт		

Жаг: Аймгуудын барилгын материалын хэлтсийн дарга нар болон барилгын материал хариуцсан мэргэжилтэн нар хамрагдах боломжтой.

Сургалтад хамрагдаж буй албан хаагч нар бүгд камераа өгч оролцох





Монгол Улсын засгийн газар болон “ЖАЙКА”/Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага/-ийн хамтран хэрэгжүүлж буй “Барилгын салбар дахь хөдөлмөрийн аюулгүй байдлын менежментийн чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд Дархан-Уул аймгийн ГХБХБГазраас төслийн баг болон Барилгын хөгжлийн төв, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвтэй хамтран “Аюулын дүн шинжилгээ хийх Япон маягийн тэргүүн туршлага” сэдэвт 8 цагийн сургалтыг Дархан хотноо 2 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулагдсан сургалтад танхимаар Барилгын асуудал хариуцсан мэргэжилтэн С.Ундрах оролцсон. Тус сургалтад Дархан-Уул аймгийн барилгын салбарын төрийн болон хувийн хэвшлийн төлөөлөл болсон 80 гаруй (ажил олгогч, менежер, ИТА, ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан зэрэг) хүмүүс хамрагдлаа.



Хот байгуулалтын кадастр, зураг төсөл магадлал хариуцсан мэргэжилтэн М.Дарьсүрэн нь Газар Зохион байгуулалт геодези зураг зүйн газраас зохион байгуулсан 21 аймгийн газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газрын кадастрын асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг хамруулсан Газрын нэгдмэл сангийн цахим систем, Төрийн өмчийн газрын мэдээллийн сан, хаягжуулалтын мэдээллийн системийн талаарх чадавхжуулах сургалтанд 2022.03.09-2022.03.11ны хооронд хамрагдсан. 2022.03.03-нь өдөр Хот байгуулалт, төлөвлөлт магадлалын асуудал хариуцсан мэргэжилтэн М.Дарьсүрэн нь Urban.gov.mn кадастрын системийн сургалтад суусан.



- ✚ 2022.03.03-ны өдөр Суурь судалгаа, газрын мониторинг хариуцсан мэргэжилтэн Агентлагаас зохион байгуулсан Мониторингийн цахим системд хэрхэн ажиллах талаарх цахим сургалтанд хамрагдсан. /zoom/
- ✚ 2022.03.04-ны өдөр “Эмэгтэйчүүдийн эрх зөрчигдөж буй тодорхой асуудал” хэлэлцүүлэгт zoom meeting хүний нөөцийн мэргэжилтэн Б.Золбаясах холбогдож оролцов.
- ✚ ТАЗөвлөлийн 7/4/10 вебинар сургалтаар “ Хүлээлтэд суурилсан гүйцэтгэлийг тодорхойлж өгөх нь” Дейл Карнеги Трейнинг Монгол сургалтын төвийн ахлах багш А.Даваасүрэн оролцож цахимаар албан хаагчдыг хамруулсан.
- ✚ Суурь судалгаа, газрын мониторинг хариуцсан мэргэжилтэн Ү.Оюундарь нь Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сургалтанд сууж гэрчилгээ авсан.
- ✚ Дархан-Уул аймгийн Засаг даргын 2022 оны 01-А/40 дүгээр захирамжийн хэрэгжилт, Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэр болон бодлогын баримт бичгийн 2021 оны хэрэгжилтэд хийсэн хяналт – шинжилгээ, үнэлгээний ерөнхий танилцуулга, 2022 онд анхаарах буюу эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүд , эдгээрийг шийдэх гарц шийдэл боломжийн талаар санал солилцох, мэргэжил арга зүйн зөвлөгөө чиглэл өгөх зорилгоор ХШҮХ-ийн дарга баталсан удирдамжийн дагуу агентлагуудад зөвлөн туслах үйлчилгээг 2022 оны 03 дугаар сарын 23 -ны өдөр зохион байгуулсан сургалтад хамрагдсан.



ЭБАТ:

- ✚ Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын эрх зүйн харилцааны хуралдааны 3 дугаар сарын хуваарь болон барилгын ажлын хяналтын дагуу Ашиг сонирхлыг зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг 9 албан хаагчаас авч <https://meduuleg.iaac.mn/AOS/Login> бүртгэлд оруулсан. Газрын эрх зүйн харилцааны хуралдааны хуваарийн дагуу хуралдаж нийт 94 иргэн, хуулийн этгээдийн газартай холбоотой материалыг хэлэлцэж шийдвэрлэсэн.

Бусад ажил:

- ✚ Байгууллагын эцэг эхийн зөвлөл нь аймгийн Засаг даргын 2021 оны бусад байгууллагуудын эцэг эхийн зөвлөлтэй хамтран хүүхдийн хамгаалал, аюулгүй




байдлын талаар мэдээ мэдээлэл солилцон туршлага хуваалцан хамтран ажилласан.



Мэдээлэл технологийн чиглэлээр:

Мэдээлэл:

- 70376471 утсаар 26 иргэн, ААНБ-ын асуусан асуултанд, Дархан-Уул аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Facebook хуудсанд иргэнээс асуусан 13 асуултанд хариулсан. 2022-03-03-нд Цахим төвд жижүүрлэн газартай холбоотой хүсэлт өгөхөөр ирсэн иргэдэд Газрын цахим системийг хэрхэн ашиглах талаар заавар, зөвлөгөө өгч ажиллав.



- Байгууллагын цахим хуудасны санал гомдол хэсэгт ирүүлсэн 12 асуултыг хэвлэж архив, бичиг хэргийн ажилтанд өгөв.

Хугацаа	Тайлан	Тайлангийн үндэслэл	Тайлангийн үндэслэл
2022.01.04	2022.01.04 өдрийн эцэс, хурлын эцэсийн хурлаар зөвлөлийн даргын томилсон		
2022.03.03	Цахим төвд жижүүрлэн газартай холбоотой хүсэлт өгөхөөр ирсэн иргэдэд Газрын цахим системийг хэрхэн ашиглах талаар заавар, зөвлөгөө өгч ажиллав.		
2022.03.03	Байгууллагын цахим хуудасны санал гомдол хэсэгт ирүүлсэн 12 асуултыг хэвлэж архив, бичиг хэргийн ажилтанд өгөв.		


Мэдээллийн технологи:

Байгууллагын цахим хуудасны өгөгдлийн сангийн нөөцлөлт хийв. Мөн цахим хуудсан дээр дараах мэдээллүүдийг байрлуулав. Үүнд:

- ✓ Ил тод байдал цэсний Санхүүгийн мэдээ хэсэгт 2022 оны 1, 2-р сарын байгууллагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, 2021 оны санхүүгийн тайлан
- ✓ Ил тод байдал цэсний Хүний нөөц хэсгийг 3 хэсэг болгож хуваан мэдээлэл нэмж оруулав.
- ✓ Ил тод байдал цэсний Үйл ажиллагааны тайлан хэсэгт байгууллагын 1,2-р сарын 7 хоног, сарын тайлан, 3-р сарын 1,2-р долоо хоногийн тайлангуудыг байрлуулав.




- ✓ Санал гомдол хүлээн авах хэсгийн кодыг шинээр бичиж, тестлэн ажиллагаанд оруулав. Зарлал хэсгийг Санал хүсэлт болгон өөрчилж санал гомдол хүлээн авах зурган линк үүсгэн байрлуулав.
- ✓ “Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аянд ГХБХБГ-ын хамт олон нэгдсэн тухай мэдээлэл
- ✓ Зарлал хэсгийг Санал хүсэлт болгон өөрчилж санал гомдол хүлээн авах зурган линк үүсгэн байрлуулав.
- ✓ Дархан суманд газар эзэмшүүлэх цахим дуудлага худалдааны зар



ГХБХБГ-ын Facebook хуудсан дээр дараах мэдээллүүдийг байрлуулав.


- ✓ “Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аянд ГХБХБГ-ын хамт олон нэгдсэн тухай мэдээлэл
- ✓ Байгууллагын цахим хуудасны санал, гомдол хүлээн авах хэсгийн холбоосыг QR код үүсгэн байрлуулав.
- ✓ Дархан суманд газар эзэмшүүлэх цахим дуудлага худалдааны зар



Иргэн танд Дархан-Уул аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын талаар санал, хүсэлт б... See more



#ДАРХАН СУМАНД 2022-04-08-НД ЦАХИМААР #ГАЗАР #ЭЗЭМШҮҮЛЭХ #ЦАХИМ #ДУУДЛАГА #ХУДАЛ... See more



2022-03-16-аас 2022-03-18-ны хооронд Улаанбаатар хотод Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Орон зайн мэдээллийн технологийн хэлтсээс зохион байгуулсан Active directory, Domain control-ийн сургалтанд хамрагдлаа.



Нярав:

30 ширхэг Нэгж талбарын хувийн хэрэг нугалж, газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүдэд олгоход бэлтгэв. Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүдэд 47 ширхэг нэгж талбарын хувийн хэргийн хавтас олгов.

Шаардах хуудсаар 12 төрлийн 69 ширхэг бараа материал олгов. 2-р сарын бараа материалын зарцуулалтын тайланг нэгтгэж ня-бод өгөв.




2021 оны газар эзэмших, ашиглах гэрчилгээ /ААНБ, ТБ/ зарцуулалтын тайлан, ААНБ-ын Улсын тэмдэгтийн хураамжийн тайланг үдэж, хавтаслан, хуудсыг дугаарлаж архивт хүлээлгэн өгөв. 2021 оны 9-12-р сарын Нэгж талбарын хувийн хэргийн хавтасны зарцуулалтын тайланг үдэж, хавтаслан, хуудсыг дугаарлаж архивт хүлээлгэн өгөв.

Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн талаар:

✚ ГХБХБГ-т 2022 оны 2 сарын 21-ний өдрөөс 3 сарын 23-ны өдрийн хооронд Абле программд нийт 112 албан бичиг /хариутай 80/, 26 өргөдөл /хариутай 22/ ирсэнээс 49 албан бичиг, 9 өргөдөл шийдвэрлэн, 31 албан бичиг, 13 өргөдөл хяналтанд бүртгэжээ.

Албан бичиг, өргөдлийн шийдвэрлэлтийг графикаар харуулбал:

График 1. Албан бичиг, өргөдлийн шийдвэрлэлт, хяналтанд авч судлаж буй талаарх мэдээлэл



✚ Мөн Egazar.gov.mn системээр 194 цахим өргөдөл хүсэлт хүлээн авсан бөгөөд тус системийн шийдвэрлэлтийн тайлан гаргадаг цэс нь одоогоор ажиллахгүй байгаа тул шийдвэрлэлтийн дүнг гаргах боломжгүй байна.

БОЛОВСРУУЛСАН:

ЗАХИРГАА, ХУУЛИЙН АСУУДАЛ

ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Б.ЗОЛБАЯСАХ

ХЯНАСАН:

ГАЗРЫН УДИРДЛАГЫН

ХЭЛТСИЙН ДАРГА

Г.НЯМДОРЖ